


2024 ОНЫ 03 ДУГААР САРЫН УУР АМЬСГАЛЫН ТОЙМ

Хаврын улиралд цаг агаар тогтворгүй байдагтай холбоотой агаарын температурын хэлбэлзэл ихэсдэг. Манай орны 3 дугаар сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Хангай, Хөвсгөлийн уулархаг нутаг болон томоохон гол, нуурын сав газраар -12°C (10.4°F) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар -5°C (23°F) –аас $+3^{\circ}\text{C}$ (37.4°F), бусад нутгаар -6°C –аас -12°C (21.2°F –аас 10.4°F) хүйтэн байдаг байна.


Монгол орны хэмжээнд 3 дугаар сард хур тунадас бага унадаг ба ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 2 хувьтай тэнцдэг. Тус сард Булган, Хэнтийн зүүн хойд, Хангайн нурууны зүүн хэсгээр 5-10 мм, Өлгий, Ховд болон Увс, Говь-Алтайн баруун хэсэг, Дундговь, Дорноговь аймгийн нутгаар 0.2-2.0 мм бусад нутгаар 1.5-4 мм тунадас ордог байна.



Зураг 1. 1991-2020 оны 3 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр нийлбэр хур тунадасны орон зайн тархалт


2024 оны 3 дугаар сарын агаарын дундаж температур өмнөх жилээс -2.7°C хүйтэн, ОЖД-аас $+0.8^{\circ}\text{C}$ -аар дулаан байсан ба 1940 оноос хойш тохиолдож байгаа 21 дэх дулаан сар болж өнгөрлөө. Сарын агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзэхэд (Зураг 2) нутгийн 58.1% нь дунджаас $+1.0$ -ээс $+3.8^{\circ}\text{C}$ -аар дулаан, 31% нь дунджийн орчим, 10.9% нь дунджаас хүйтэн байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 2.1 мм хур тунадас орсон нь өмнөх жилээс 40.7%, ОЖД-аас 29.5%-иар тус тус бага бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 30 дахь хур тунадас багатай сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 82.2% нь дунджаас бага, 16.3% нь дунджаас ахиу, 1.6% -д дунджийн орчим хур тунадас унасан байна.




Зураг 2. 2024 оны 3 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын газарзүйн тархалт

Монгол орноор болон 4 бүсээр хуваан дунджилсан 3 дугаар сарын агаарын температурын хоногийн явцыг авч үзэхэд (Зураг 3) 1 дүгээр 10 хоногт нийт нутгаар ОЖД-аас -1.0 -ээс -6.6°C -аар хүйтэн, 2 дугаар 10 хоногт болон 3 дугаар 10 хоногт ихэнх нутгаар ОЖД-аас $+1.1$ -аас $+9.0^{\circ}\text{C}$ дулаан байсан. Харин 3 дугаар 10 хоногийн сүүлээр зүүн бүс нутгаар ОЖД-аас -1.6 -оос -3.3°C -аар хүйтрэлт ажиглагдсан. Хур тунадасны хувьд 2 дугаар 10 хоногийн дундуур болон 3 дугаар 10 хоногт нийт нутгаар харьцангуй ахиу хур тунадас оржээ.



Зураг 3. Хоногийн дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Энэ сард агаарын температурын үнэмлэхүй их утга Баянхонгорын Эхийнголд 25°C , үнэмлэхүй бага утга Завханы Отгонд -38.6°C хүрчээ. Хөрсний температурын үнэмлэхүй их утга Баянхонгорын Эхийнголд 46°C , үнэмлэхүй бага утга Баянхонгорын Байдрагт -40°C хүрч хүйтэрсэн. Хоногт хамгийн ихдээ Дорнодын Халхголд 16-ны өдөр 12.1 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 953.1гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 760.5гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Дундговийн аймгийн Говь-Угтаал суманд 30 м/с хүрчээ.



Зураг 4. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд